



**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 5/17

Улаанбаатар хот

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1.1, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 2 дугаар зүйлийн 2.1.1, 2.1.5, "Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай" 2020 оны 209 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1280 дугаартай захирамжийн 9 дүгээр заалт, төвийн даргын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/29 дүгээр тушаал, 2019 оны А/10 дугаартай тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.3, 10.8 дахь заалтууд, төвийн Даргын дэргэдэх зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төвийн нийгмийн ажилтан Б.Цогзол нь албан ажилдаа хариуцлагагүй хандан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын үед үйлчлүүлэгч иргэдийн шалтгааныг судлан тогтоохгүй удаа дараа чөлөө олгож, хөл хорио, халдвар хамгааллын аюулгүй байдлыг алдагдуулсан тул сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Цаашид эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандаж, цаг үеийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт хийж, санаачлагатай ажиллахыг Б.Цогзолд зөвлөсүгэй.

ДАРГА



Г.ЦЭРЭНДУЛАМ

31806031